



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2020 оны 10 сарын 20 өдөр

Дугаар А/620

Ховд

Газар эзэмших эрх шилжүүлэх тухай


Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1, 38.3, 38.4 дэх заалт, Хаягжуулалтын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэг, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2010 оны 267 дугаар тогтоол, Жаргалант сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2016 оны 143 дугаар тогтоолуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Жаргалант сумын Цамбагарав багийн Лааганы 1 дүгээр гудамжны 122 тоотод байрлах гэр орон сууцны зориулалттай “Оюу мандал” ХХК /2033011/-ний эзэмшлийн 2130 метр квадрат газраас 1000 метр квадрат газрыг газар эзэмших эрх шилжүүлэх гэрээний дагуу Басбишийн Алтангэрэл /ПЮ89090173/-д хаягийг Лааганы 1 дүгээр гудамжны 122 а тоот болгон 8 жилийн хугацаагаар, үлдсэн 1130 метр квадрат газрыг “Оюу мандал” ХХК /2033011/-д 8 жилийн хугацаатайгаар шилжүүлэн эзэмшүүлсүгэй.

2. Газар эзэмших эрхийг хуулийн дагуу шилжүүлэн авч, газраа зориулалтын дагуу үр ашигтай, зүй зохистой эзэмшиж, ашиглаж, хамгаалж, газар эзэмшүүлэх гэрээнд заасан нөхцөл болзлыг биелүүлж ажиллахыг дээрх иргэн, аж ахуй нэгжид үүрэг болгосугай.

3. Газар эзэмших эрх нь баталгаажсан иргэн, аж ахуй нэгжтэй газар эзэмшүүлэх гэрээ байгуулж, газар эзэмших эрхийн гэрчилгээ олгон, газрын төлбөрийг хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэн гэрээний биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар /Э.Дөлбадрал/-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

Zax A/620 Ch  
02 2807